Герман хэлний мэдлэг

Германд оршин сууж байгаа эхнэр/нөхөр дээрээ нүүж очих, германд гэрлэлтээ бүртгүүлэх зорилгоор үндэсний виз мэдүүлэхэд герман хэлний анхан шатны мэдлэгтэй гэдгээ батлах ёстой. Энэ тохиолдолд герман хэлний А1 түвшний мэдлэг хангалттай.

Монголд дахь Гёте-Институтын сертификатыг Германы ЭСЯ одоогийн байдлаар герман хэлний мэдлэгийн баримт гэж хүлээн зөвшөөрч байгаа болно.

Зарчмын хувьд виз мэдүүлэхдээ герман хэлний мэдлэгийн баримтаа хамт өгөх ёстой.

Виз мэдүүлэх үед хэлний мэдлэгийн баримт (Гёте-Институтын сертификат) хараахан гараагүй нөхөн өгч болно. Виз мэдүүлэгч өөрийн герман хэлний мэдлэгийг ЭСЯ-ны ажилтантай ярилцлага хийж батлах боломжтой.

Хэлний мэдлэгээ баталсан баримтаа авчирч өгөөгүй бол бусад нөхцөл бүрдсэн байсан ч визийн мэдүүлгэнд татгалзсан шийдвэр өгөх болно.